



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 61

Ховд

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з”, 19 дүгээр зүйлийн 19.1.4, 25 дугаар зүйлийн 25.4, Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16. 2, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтууд, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны “Хуралдаан зарлах тухай” 49 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасан хэлэлцэх асуудлын жагсаалтад дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай. Үүнд:

1.5.Аймгийн газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Илтгэгч нь: Аймгийн ГХБХБГ-ын дарга Э.Дөлбадрал

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 62

Ховд

┌ Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Жаргалант сумын “Жаргалан өрхийн эрүүл мэндийн төв”-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа 14965027 төгрөг /арван дөрвөн сая есөн зуун жаран таван мянга хорин долоо/-ийн балансын үнэ бүхий өрхийн эмнэлгийн барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийн нийтийн дуудлагын худалдааг 2018 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын 415 тоот өрөөнд зохион байгуулсугай.

3.Жаргалант сумын “Жаргалан өрхийн эрүүл мэндийн төв”-ийн эрхлэгч /Х.Нуржан/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

3.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, хавсралтад заасан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 63

Ховд

Хөрөнгө шилжүүлэх санал уламжлах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8, 31 дүгээр зүйлийн 31.1,2,3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 179645200.0 төгрөг /Нэг зуун далан есөн мянга зургаан зуун дөчин таван мянга хоёр зуу/-ийн балансын үнэ, 50150951.0 төгрөг /тавин сая нэг зуун тавин мянга есөн зуун тавин нэг/-ийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Зэвсэгт хүчний 325 дугаар ангид балансаас балансад шилжүүлэх саналыг дэмжин Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт уламжилсугай.

2.Хөрөнгө шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/, Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/ нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 64

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын 2018 оны 4 дүгээр улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож, Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 65

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

Монгол Улсын “Аж үйлдвэрийн гавьяат ажилтан”-аар

1. Дунжуур Хүрэлжээ - Баруун бүсийн Эрчим хүчний систем  
ТӨХК-ны Ховд аймаг дахь салбар  
зөвлөх инженер

Монгол Улсын “Гавьяат тээвэрчин”-ээр

1. Лхаасүрэн Ганболд - “Зорчигч тээвэр ХХК”-ны захирал

Монгол Улсын “Гавьяат эдийн засагч”-аар

1. Чүлтэмсүрэн Цэрэнчимэд - Ховд аймаг дахь Төрийн аудитын  
ахмад ажилтан

Монгол Улсын “Гавьяат мал зүйч”-аар

1. Доржбал Бальдиржамц - “Сутай үүлдэр” ХХК-ны захирал

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор

1. Лужигнаа Даваа - Булган сум Байтаг багийн малчин
2. Цэрэндорж Отгонбаатар - Эрдэнэбүрэн сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга

“Алтан гадас одон”-оор

1. Пилжин Должин - Буянт сумын хүн эмнэлгийн өндөр настан
2. Түдэв Ганхүү - Чандмань сум Бумбатын сүрэг хувийн мал эмнэлгийн захирал
3. Балдорж Цэенхүү - Эрдэнэбүрэн сум Намарзан багийн малчин
4. Самдан Эрдэнэбаатар - Жаргалант сумын Бугат багийн өндөр настан
5. Шарав Хулгана - Жаргалант сумын Алагтолгой багийн өндөр настан
6. Жаргал Цогтоо - Манхан сумын Ботгон багийн өндөр настан
7. Бярзана Цэцэгтуяа - “Аз-Эрдэнэ ЗБ” нөхөрлөлийн худалдагч, тогооч
8. Уртнасан Пүрэвдорж - “Ховд ЦТС ХХК” Ерөнхий инженер
9. Гармаа Булгаа - “Ховд ЦТС ХХК”-д гагнуурчин-монтёр
10. Домысхан Жолды - Ховд сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга буюу ерөнхий нягтлан бодогч
11. Канау Авсадых - Ховд сумын Дунд ус багийн иргэн
12. Ламжав Цэндсүрэн - Хөгжил Политехник коллежийн ХАА-н тэнхимийн эрхлэгч
13. Дэнгэнбай Сарьсанбай - Хөгжил Политехник коллежийн ажилтан
14. Болиогийн Бямбажав - Жаргалант сумын 2 дугаар сургуулийн багш
15. Сүхийн Жавзмаа - Жаргалант сумын 2 дугаар сургуулийн багш

- |                           |  |
|---------------------------|--|
| 16. Халхын Эрхэмбаяр      | - ХДТ-ийн уран сайхны удирдагч,<br>ерөнхий хормейстр |
| 17. Банзрайн Нямдорж      | - Эрдэнэбүрэн сумын ЗДТГ-ын жолооч                   |
| 18. Цэрэндашийн Цогбадрах | - Жаргалант сумын Жаргалан багийн<br>иргэн           |
| 19. Дарийн Баатардорж     | - Хаш түлхүүр” жолооны сургуулийн багш               |
| 20. Намидын Сүхбат        | - Жаргалант сумын Тахилт багийн иргэн                |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар

- |                         |  |
|-------------------------|--|
| 1. Тогооням Отгонзаяа   | - Дуут сумын ЕБС-ийн Монгол хэлний<br>багш                   |
| 2. Цагаач Тунгалаг      | - Дуут сумын ЕБС-ийн бага ангийн багш                        |
| 3. Намсрай Наранхүү     | - Хөгжил политехник коллежийн архивын<br>эрхлэгч             |
| 4. Дангаа Баясгалан     | - Хөгжил политехник коллежийн мужаан                         |
| 5. Дүгэржав Хорлоо      | - Жаргалант сумын 5, 10 дугаар<br>цэцэрлэгийн нягтлан бодогч |
| 6. Оодгой Тунгалаг      | - Жаргалант сумын 14-р цэцэрлэгийн<br>Эрхлэгч                |
| 7. Мижиддорж Цэцэгсүрэн | - Жаргалант сумын Алагтолгой багийн<br>иргэн                 |

ХУРЛЫН ДАРГА



Г. ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 66

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор “Аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулганыг” 2018 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. “Аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулганыг” зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. “Аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулганыг” зохион байгуулах талаарх мэдээллийг төрийн захиргааны болон төсөл хөтөлбөрийн байгууллагууд, гадаад, дотоодын түншлэгчид, бизнес эрхлэгчид, иргэд, олон нийтэд өргөнөөр сурталчлан бэлтгэл ажлыг хангаж, өндөр хэмжээнд зохион байгуулж үр дүнг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан дүгнэж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга, ажлын хэсгийн дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 67

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Хөдөлмөрийн баатар” цолоор

1. Чанаг Арслан - Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн малчин

“Алтан гадас одон”-оор

1. Түмэнжаргал Цэвэлмаа - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ахмад ажилтан

2. Балдандорж Жаргалсайхан - “НИК” ХХК-ийн Ховд аймаг дахь Нефть хангамжийн салбарын тээврийн жолооч

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 68

Ховд

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны “Мал эмнэлгийн ажил үйлчилгээ, шинжилгээний хөлсний норматив тогтоох тухай” 73 дугаар тогтоол, 2015 оны “Журам батлах тухай” 18 дугаар тогтоол, 2017 оны “Журам батлах тухай” 48 дугаар тогтоолуудыг 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг ханган, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, 2018 оны 11 дүгээр сард багтаан аймгийн ИТХ-ын Хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барихыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 69

Ховд

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11, 28, 29, 80 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 90 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслэх журмын шинэчилсэн найруулгыг батлах тухай”, 2017 оны 91 дүгээр тогтоолоор баталсан “Түрээсийн гэрээний загвар баталж, төлбөрийн доод үнэ тогтоох тухай”, Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй эд хөрөнгийг худалдах дуудлагын худалдааг орон нутагт зохион байгуулах харилцааг зохицуулсан 2017 оны “Журам батлах тухай” 93 дугаар тогтоолуудыг 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолууд хүчингүй болсонтой холбогдуулан түрээс, дуудлага худалдааны харилцааг зохицуулахад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 119, 128 дугаар тогтоолоор баталсан журмуудыг мөрдөж, орон нутгийн өмч /орон нутгийн өмчийн оролцоотой/-ийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төсөвт байгууллагууд, иргэд, олон нийтэд сурталчилж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 70

Ховд

Хуралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.1.1-ийн “д”, 18.1.2-ын “б”, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.5, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдааныг 2018 оны 11 дүгээр сарын 30, 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд Ховд хотод, аймгийн Нутгийн удирдлагын ордонд хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1.1. “Аймгийн ИТХ-ын 2018 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай”

Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын дарга Г.Пүрэвганди

1.2. “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилт, тайлангийн жилийн биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлсэн дүн, цаашдын зорилтын тухай”

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

1.3. Аймгийн төсвийн 2018 оны урьдчилсан гүйцэтгэл, 2019 оны төсвийн төслийн тухай”

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

1.4. “Аймгийн 2019 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар аймгийн Аудитын газраас өгөх саналын тухай”

Илтгэгч нь: Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор Х.Болдбаатар

1.5. Газар зохион байгуулалтын асуудал:

а. “Аймгийн газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн, 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийн тухай”

Илтгэгч нь: аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

б. “Эрдэнэбүрэн сумын хилийн цэсийг өөрчлөн тогтоох саналын тухай”

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

1.6. Журмуудыг хэлэлцэн батлах тухай:

а. “Мал эмнэлгийн ажил үйлчилгээ, шинжилгээний хөлсний норматив тогтоох тухай”

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

б. “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

в. “Ховд аймгийн орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж сэтлэх, нөхөн сэргээх ажлын зөвшөөрөл олгох, гүйцэтгэх журам”-ын тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав

г. “Аймгийн нутаг дэвсгэрт хамаарах усан сан бүхий газруудын энгийн болон онцгой хамгаалалтын бүсийн хилийн цэсийг тогтоох тухай”

2. Аймгийн ИТХ-ын 8 дугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлыг нийтэд мэдээлж, хуралдааны бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 71

Ховд

“Төлөөлөн удирдах зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Ховд Хөшөөт хөгжил сан”-гийн журмын 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Ховд Хөшөөт хөгжил сан”-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Төлөөлөн удирдах  
зөвлөлийн дарга:

Г.Пүрэвганди - Аймгийн ИТХ-ын дарга

Гишүүдэд:

Т.Жаргалсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Ж.Гөлгөө - МоЭнКо ХХК-ны Засгийн газар, төр олон нийттэй  
харилцах асуудал эрхэлсэн захирал

Ю.Азамат - Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч

Ц.Бат-Эрдэнэ - Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

2.Тус тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны “Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 90 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж орлогын бүрдүүлэлт, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хөрөнгө оруулалтын үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын дарга, сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Г.Пүрэвганди/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 72

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

Монгол Улсын “Гавьяат малчин”-аар

1. Цэрэннадмид Насанжаргал - Эрдэнэбүрэн сумын Шураг багийн малчин

Монгол Улсын “Гавьяат тээвэрчин”-ээр

1. Лхагважав Аюурзана - Ховд аймгийн тээвэрчдийн холбооны өндөр настан

“Сүхбаатарын одон”-оор

1. Содном Гаахүү - Ганданпунцагчойлон хийдэд лам

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон-оор

1. Бөхчулуун Мундуу - Ховд аймгийн Манхан сумын өндөр настан  
2. Мажин Даваадай - Жаргалант сумын Бичигт багийн өндөр настан  
3. Дашзэвэг Должин - Жаргалант сумын Тахилт багийн өндөр настан



- |                         |   |
|-------------------------|---|
| 4. Ноосгой Баатарсүрэн  | - Жаргалант сумын 3-р сургуулийн<br>математикийн багшаар ажиллаж<br>байсан ахмад настан |
| 5. Санжмятав Баттулга   | - Эрдэнэбүрэн сумын өндөр настан  |
| 6. Жамсран Батхуяг      | - Жаргалант сумын Алагтолгой багийн<br>өндөр настан                                     |
| 7. Чанаг Баатарзаан     | - Ховд аймгийн нисэх буудлын онгоцны<br>техникч   |
| 8. Даваасүрэн Мөнхтөмөр | - Зоонозын өвчин судлалын төв   |
| 9. Бааст Жарантай       | - Буянт сумын Цагаан эрэг багийн өндөр<br>настан, малчин                                |

“Алтан гадас одон”-гоор

- |                        |   |
|------------------------|---|
| 1. Бөхчулуун Мөнхтөмөр | - Ховд аймгийн “УАА эвлэл” ХХК ерөнхий<br>инженер                           |
| 2. Дашням Рэнцэнбямбаа | - “Шандны булаг” ХХК ажилтан  |
| 3. Санж Отгонбаяр      | - Голомт банк Ховд дахь салбарт<br>үйлчлэгч                                 |
| 4. Короо Санж          | - Жаргалант сумын Магсаржав багийн<br>өндөр настан                          |
| 5. Няндун Бямбасүрэн   | - Ховд аймаг Цаст-Алтай цогцолбор<br>сургуульд Түүхийн багш                 |
| 6. Агваан Сайнбилэг    | - Ховд аймгийн Хөгжим драмын театрт<br>хөгжмийн багш                        |
| 7. Нямаа Баттулга      | - Үенч сумын Цагаан түнгэ багийн<br>малчин                                  |
| 8. Монгио Нина         | - Үенч сумын соёлын төвийн эрхлэгч  |
| 9. Пунцаг Охин         | - Эрдэнэбүрэн сумын Нэгдсэн эмнэлэгт<br>эх баригч, бага эмч                 |
| 10. Бат Тогтох         | - Алтай сумын Алтан гадас багийн<br>малчин                                  |
| 11. Нанжид Цэрэндулам  | - Ховд аймгийн нэгдсэн эмнэлэгт<br>асрагчаар ажиллаж байсан<br>өндөр настан |

- |                          |  |
|--------------------------|--|
| 12. Дорж Энхтуяа         | - Ховд аймгийн Ахуй үйлчилгээний<br>комбинатад оёдолчин, эсгүүрчин                         |
| 13. Бямба Дамба          | - Буянт сумын Нарийн гол багийн малчин   |
| 14. Батжаргал Бадамцэрэн | - Мянгад сумын ЕБС-ийн дуу хөгжмийн<br>багш  |
| 15. Нямаахүү Халтар      | - Жаргалант сумын Хүрэн хошуу МЭҮН-д<br>малын их эмч                                       |
| 16. Шаравжамц Нямсүрэн   | - Эрдэнэбүрэн сумын Тунгалаг уст шураг<br>хоршооны дарга                                   |
| 17. Балдорж Цэгмид       | - Ховд аймгийн Татварын хэлтсийн<br>улсын байцаагч, ахмад настан                           |
| 18. Цагаан Гиймаа        | - Ховд аймгийн нэгдсэн эмнэлэгт<br>жолоочоор ажиллаж байсан<br>ахмад настан                |
| 19. Гаальчиг Жавзмаа     | - Ховд аймгийн Нийтийн номын сангийн<br>ахлах номын санчаар<br>ажиллаж байсан ахмад настан |
| 20. Галаа Ядамсүрэн      | - Буянт сумын Цагаан эрэг багийн ардын<br>өндөр настан, малчин                             |
| 21. Шайеин Калим         | - Буянт сумын Цагаан эрэг багийн өндөр<br>настан, малчин                                   |
| 22. Батхүү Дашдаваа      | - Буянт сумын Нарийн гол багийн ахмад<br>настан, малчин                                    |
| 23. Балдан Мөнхтөр       | - Буянт сумын өндөр настан   |
| 24. Цэвээндорж Ганчулуун | - Булган сумын МАХН-ын дарга   |
| 25. Балжинням Догмидмаа  | - Булган сумын бизнес эмэгтэйчүүдийн<br>зөвлөлийн дарга                                    |
| 26. Жижий Цогтсайхан     | - Алтай сумын Барлаг багийн өндөр<br>настан, малчин  |
| 27. Нооноо Идэш          | - Алтай сумын Барлаг багийн өндөр<br>настан, малчин  |
| 28. Пунцаг Даваагарам    | - Алтай сумын Барлаг багийн өндөр<br>настан, малчин  |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар

- |                       |                                    |
|-----------------------|------------------------------------|
| 1. Баатархүү Гантөмөр | - Ховд аймгийн Засаг даргын Тамгын |
|-----------------------|------------------------------------|



газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ  
хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Хүрлээ Ундрэм - Жаргалант сумын Алагтолгой багийн  
ахмад настан
3. Лхамсүрэн Цэцэгсүрэн - Жаргалант сумын Хайрхан багийн  
ахмад настан
4. Мухаан Кендебай - Жаргалант сумын Наран багийн өндөр  
настан
5. Өлзийтогтох Баяраа - Буянт сумын Нарийн гол багийн өндөр  
настан
6. Гап Батаа - Буянт сумын Нарийн гол багийн  
даргаар ажиллаж байсан  
өндөр настан
7. Илэе Хуан - Буянт сумын эрдэм шинжилгээний  
станцад тракторч, комбайнч
8. Лхамхүү Нанжид - Алтай сумын Барлаг багийн өндөр  
настан, малчин
9. Цэрэн Хөөт - Алтай сумын Барлаг багийн өндөр  
настан, малчин
10. Бөхчулуун Энхжаргал - Алтай сумын Барлаг багийн малчин
11. Лхамхүү Цэндсүрэн - Алтай сумын Барлаг багийн өндөр  
настан, малчин
12. Тогтбек Оюунцэцэг - Булган сумын бизнесмен
13. Ядамсүрэн Нэргүй - Ховд аймгийн Бүсийн оношилгоо  
эмчилгээний төвийн арьс харшлын  
тасгийн сувилагч

ХУРЛЫН ДАРГА



Г. ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 78

Ховд

“Хэрэглэгчийн эрхийг хамгаалах”  
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, дахь заалт, Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах” аймгийн дэд хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

2.1. “Хэрэглэгчийн эрхийг” хамгаалах аймгийн дэд хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан холбогдох байгууллагуудын салбар дундын бодлого зохицуулалтыг удирдлага зохион байгуулалтаар хангаж иргэд, Төрийн бус байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх арга хэмжээ авах

2.2. Тус дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв болон гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн байгууллагуудын санхүүжилтэд тусгаж хэрэгжүүлэх

2.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг тухай бүр тооцож иргэд, олон нийтэд мэдээлж ажиллах

2.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж,



Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт 02 дугаар сарын 01-ний дотор хүргүүлэх

3.Тус тогтоолын биелэлтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 74

Ховд

Хөрөнгө шилжүүлэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 5.1 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дарви сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2013 онд ашиглалтад орсон 30000 км гүйлттэй, 8089УНГ улсын дугаартай, 810033793 тоот арлын дугаартай, хар ногоон өнгөтэй 26000000 төгрөг /хорин зургаан сая/-ийн балансын үнэтэй, 15600000 төгрөг /арван таван сая зургаан зуун мянга/-ийн хуримтлагдсан элэгдэл бүхий Ланд крузер-80 автомашиныг тус сумын Цагдаагийн тасагт ашиглуулахаар аймгийн Цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шилжүүлж буй автомашиныг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад үндсэн хөрөнгийг шилжүүлэх, хүлээн авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн тогтоолын биелэлтийг 2018 оны дөрөвдүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Дарви сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Л.Мөнхжаргал/, аймгийн Цагдаагийн газрын дарга /Б.Батзаяа/ нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  ПҮРЭВГАНДИ







ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 75

Ховд

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах данснаас хасах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөст сумын 2017 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 30000000 төгрөг /гучин сая/-ийн үнэ бүхий 160 ква цахилгааны дэд станцыг балансад бүртгэхийг Мөст сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Соёлмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад нягтлан бодох бүртгэлд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж тус тогтоолын биелэлтийг 2018 оны дөрөвдүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Мөст сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Соёлмаа/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г. ПҮРЭВГАНДИ







ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 76

Ховд

Хөрөнгө акталж данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Алтай сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хавсралтад заасан ашиглалтын шаардлага хангахгүй нийт 16 нэр төрлийн 18 ширхэг 15308405 төгрөг /арван таван сая гурван зуун найман мянга дөрвөн зуун тав/-ийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг акталж данснаас хасахыг тус сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Баатарсүрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх, бүртгэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж нягтлан бодох бүртгэлд тусган тус тогтоолын биелэлтийг хангаж дүнг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Алтай сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Баатарсүрэн/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 77

Ховд

Хөрөнгө акталж данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хавсралтад заасан ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 6 нэр төрлийн 92 ширхэг 22543352 төгрөг /хорин хоёр сая таван зуун дөчин гурван мянга гурван зуун тавин хоёр/-ийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг акталж данснаас хасахыг тус сумын сургуулийн захирал /Т.Цэцэгбадам/-д зөвшөөрсүгэй.

2. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх, бүртгэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж нягтлан бодох бүртгэлд тусган тус тогтоолын биелэлтийг хангаж дүнг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг сумын сургуулийн захирал /Т.Цэцэгбадам/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ПҮРЭВГАНДИ







ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 78

Ховд

Хөрөнгө акталж данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Булган сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлаж ашиглах боломжгүй болсон болсон нийт 48 төрлийн 62995331 төгрөг /жаран хоёр сая есөн зуун ерэн таван мянга гурван зуун гучин нэг/-ийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийг акталж данснаас хасахыг Булган сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Ш.Ганболд/-д зөвшөөрсүгэй.

2.Акталж буй хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомж, журмын дагуу данснаас хасах, сэлбэг материалаар ашиглах, худалдах ажлыг зохион байгуулж хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Булган сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Ш.Ганболд/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 79

Ховд

Хөрөнгө акталж данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөнххайрхан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 4 төрлийн 7 ширхэг 7576289 төгрөг /долоон сая таван зуун далан зургаан мянга хоёр зуун наян ес/-ийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж данснаас хасахыг Мөнххайрхан сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /Д.Энхбулган/-д зөвшөөрсүгэй.

2. Акталж буй хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад холбогдох хууль тогтоомж, журмын дагуу данснаас хасах, сэлбэг материалаар ашиглах, худалдах ажлыг зохион байгуулж хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Мөнххайрхан сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /Д.Энхбулган/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Г. ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 80

Ховд

Хөрөнгө акталж данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2. дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөнххайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон, нийт 1 нэр төрлийн 5 ширхэг 3250000 төгрөг /гурван сая хоёр зуун тавин мянга/-ийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж данснаас хасахыг Мөнххайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Б.Түвшинзориг/-д зөвшөөрсүгэй.

2. Акталж буй хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад холбогдох хууль тогтоомж, журмын дагуу данснаас хасах, сэлбэг материалаар ашиглах, худалдах ажлыг зохион байгуулж хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Мөнххайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Б.Түвшинзориг/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА /Ш.Нохойжав/ П.ПҮРЭВГАНДИ







ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 81

Ховд

Хөрөнгө акталж данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын балансад бүртгэлтэй хавсралтад заасан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон, нийт 1 нэр төрлийн 1 ширхэг 899000 төгрөг /найман зуун ерэн есөн мянга/-ийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж данснаас хасахыг Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /О.Бишгарам/-д зөвшөөрсүгэй.

2. Акталж буй хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад холбогдох хууль тогтоомж, журмын дагуу данснаас хасах, сэлбэг материалаар ашиглах, худалдах ажлыг зохион байгуулж хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /О.Бишгарам/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ







ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 82

Ховд

Хөрөнгө акталж данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөнххайрхан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 4 нэр төрлийн 6 ширхэг 6086000 төгрөг /зургаан сая наян зургаан мянга/-ийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж данснаас хасахыг Мөнххайрхан сумын Засаг даргын Тамгын газрын даргад зөвшөөрсүгэй.

2. Акталж буй хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад холбогдох хууль тогтоомж, журмын дагуу данснаас хасах, сэлбэг материалаар ашиглах, худалдах ажлыг зохион байгуулж хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Мөнххайрхан сумын Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Т. ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 83

Ховд

Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.1 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон 2 нэр төрлийн нийт 2423800 төгрөг /хоёр сая дөрвөн зуун хорин гурван мянга найман зуу/-ийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Б.Оюунчимэг/-д зөвшөөрсүгэй.

2.Акталж буй хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад холбогдох хууль тогтоомж, журмын дагуу данснаас хасах, сэлбэг материалаар ашиглах, худалдах ажлыг зохион байгуулж хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Б.Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 84

Ховд

Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.1 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 6 нэр төрлийн 5475400 төгрөг /таван сая дөрвөн зуун далан таван мянга дөрвөн зуу/-ийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Д.Манат/-д зөвшөөрсүгэй.

2.Акталж буй хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад холбогдох хууль тогтоомж, журмын дагуу данснаас хасах, сэлбэг материалаар ашиглах, худалдах ажлыг зохион байгуулж хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Д.Манат/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш Нохойжав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Г. ПҮРЭВГАНДИ

